

ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/13/НА-СТА-ТӨА

ТӨВ АЗЗА ТӨХК-ИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН  
АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Д.Бямбасүрэн

Утас: 70272287 Цахим хаяг: byambasurend@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: [www.open.audit.mn](http://www.open.audit.mn)

## АГУУЛГА

---

1. Хараат бус аудиторын дүгнэлт .....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан .....
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
  - 3.1 Компани, түүний үйл ажиллагаа.....
  - 3.2 Компанийн гадаад, дотоод орчин .....
  - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....
  - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад гарсан өөрчлөлт .....
4. Аудитын тайлан.....
  - 4.1 Ерөнхий зүйл .....
  - 4.2 Материаллаг байдал .....
  - 4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....
  - 4.4 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт .....
  - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....
  - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....
5. Аудитын илрүүлэлт .....
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл .....

### Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УИХ	Улсын Их Хурал
ЗГ	Засгийн газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЗТХЯ	Зам Тээвэр Хөгжлийн Яам
ЗТХТ	Зам тээвэр хөгжлийн төв
ААНБ	Аж ахуй нэгж байгууллага

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум  
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn  
Цахим хаяг: www.audit.mn

2024.03.15 № 01/2023  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ТӨВ АЗЗА ТӨХК-ИЙН ЗАХИРАЛ  
Д.БОЛДБААТАР ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Төв АЗЗА ТӨХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Төв АЗЗА ТӨХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Их Хурлын 2002 оны 16 тогтоолоор баталсан Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэлийн 4 дүгээр зүйлийн 4.1-т “Доор дурдсан төрийн өмчит хуулийн этгээдийн 34 хүртэлх хувийн энгийн хувьцааг нэмж гарган Монголын хөрөнгийн биржээр олон нийтэд нээлттэй худалдан нээлттэй хувьцаат компани болгоно”, 4.1.19-д “Төв АЗЗА ТӨХК” гэж заасан байна.

### Аудитын гол асуудал

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 581 дүгээр тогтоолоор 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталж, тайлант оны нийт цэвэр ашиг 43,061.9 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 745.0 мянган төгрөгөөр буюу 1,7 хувиар буурсан нь үндсэн материалын үнийн өсөлт нөлөөлсөн байна.

### Бусад асуудлын хэсэг

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2023 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 28 дугаар хуралдааны “Төв авто замын арчлалт” төрийн өмчийн хувьцаат компанийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй хөрөнгийг орон нутгийн өмчид шилжүүлэх

G/Архив/Албан бичиг 2024/ А4

019020162

тухай асуудлыг хэлэлцээд 32 тоот тэмдэглэлээр шийдвэрлэж, Говьсүмбэр аймгийн Засаг даргад хариуцуулж, шилжүүлэхдээ Төлөөлөн удирдах зөвлөлөөс өмч шилжүүлэх зөвшөөрөлгүй, өмч хамгаалах байнгын комиссын хурлын протокол, дүгнэлтгүй, өмч эзэмшигч байгууллагын зөвшөөрлийг авсан албан бичиг тоот байхгүй, хөрөнгийг хүлээлцсэн акт үйлдээгүй байна.

#### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /			
Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>432,284,105.28</b>	<b>709,832,716.47</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>153,679,887.72</b>	<b>385,391,661.66</b>
<b>31200</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>153,679,887.72</b>	<b>385,391,661.66</b>
<b>31210</b>	<b>Төгрөг</b>	<b>153,679,887.72</b>	<b>385,391,661.66</b>
31213	Арилжааны банк дахь харилцах	153,679,887.72	385,391,661.66
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>135,792,704.72</b>	<b>8,776,175.45</b>
33402	Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	23,410,193.32	7,660,259.45
<b>33500</b>	<b>Бусад авлага</b>	<b>112,382,511.40</b>	<b>1,115,916.00</b>
33510	Байгууллагаас авах авлага	112,382,511.40	1,115,916.00
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	<b>7,757,919.95</b>	<b>0</b>
34600	Урьдчилж гарсан зардал	7,757,919.95	0
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>135,053,592.89</b>	<b>315,664,879.36</b>
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	0	180,531,010.76
35300	Бэлэн бүтээгдэхүүн	64,077,571.31	71,362,025.96
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>70,976,021.58</b>	<b>63,771,842.64</b>
35470	Бусад хангамжийн материал	70,976,021.58	63,771,842.64
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,903,532,905.47</b>	<b>1,990,757,390.08</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>1,903,532,905.47</b>	<b>1,990,757,390.08</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>1,346,619,905.47</b>	<b>1,433,844,390.08</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	550,907,687.60	550,907,687.60
39202	Хуримтлагдсан элэгдэл	-87,762,949.25	-103,615,542.50
39203	Авто-тээврийн хэрэгсэл	1,772,509,031.54	2,058,647,966.27
39204	Хуримтлагдсан элэгдэл	-903,527,098.72	-1,077,170,662.58
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	118,717,263.09	118,717,263.09
39206	Хуримтлагдсан элэгдэл	-111,879,687.34	-114,236,664.60
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	20,813,200.01	20,813,200.01
39208	Хуримтлагдсан элэгдэл	-14,134,708.00	-20,800,708.01
39214	Бусад үндсэн хөрөнгө	6,699,854.30	6,699,854.30
39215	Хуримтлагдсан элэгдэл	-5,722,687.76	-6,118,003.50
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>556,913,000.00</b>	<b>556,913,000.00</b>
39301	Програм хангамж	1,705,005.22	1,705,005.22
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,705,005.22	-1,705,005.22
39303	Бусад биет бус хөрөнгө	556,913,000.00	556,913,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>2,335,817,010.75</b>	<b>2,700,590,106.55</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>2,522,003.50</b>	<b>36,488,211.74</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>2,522,003.50</b>	<b>36,488,211.74</b>
<b>41300</b>	<b>Өглөг</b>	<b>2,522,003.50</b>	<b>36,488,211.74</b>
<b>41360</b>	<b>Бусад өглөг</b>	<b>2,522,003.50</b>	<b>36,488,211.74</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	0	32,617,014.60
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	2,522,003.50	3,871,197.14
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,333,295,007.25</b>	<b>2,664,101,894.81</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>2,333,295,007.25</b>	<b>2,664,101,894.81</b>
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	1,739,966,254.54	2,027,711,210.27
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	556,913,000.00	556,913,000.00
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>-722,759,628.61</b>	<b>-679,697,696.78</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	-770,578,160.38	-722,759,628.60
51220	Тайлант үеийн үр дүн	47,818,531.77	43,061,931.83
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	0	-0.01
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	759,175,381.32	759,175,381.32
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>2,335,817,010.75</b>	<b>2,700,590,106.55</b>

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>258,205,541.86</b>	<b>367,256,660.93</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>258,205,541.86</b>	<b>367,256,660.93</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>258,205,541.86</b>	<b>367,256,660.93</b>
120005	Түрээсийн орлого	24,600,000.00	20,500,000.00
120010	Борлуулалтын орлого (Цэвэр) /ТӨҮГ/	3,337,362,816.46	4,302,045,118.09
120011	Борлуулалтын өртөг /ТӨҮГ/	3,103,757,274.60	3,955,288,457.16
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>210,387,010.09</b>	<b>324,194,729.10</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>210,387,010.09</b>	<b>324,194,729.10</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>210,387,010.09</b>	<b>324,194,729.10</b>
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>210,387,010.09</b>	<b>324,194,729.10</b>
210811	Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/	204,881,539.89	318,887,273.13
210812	Санхүүгийн зардал /ТӨҮГ/	192,300.00	522,796.88
210814	Орлогын татварын зардал /ТӨҮГ/	5,313,170.20	4,784,659.09
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>47,818,531.77</b>	<b>43,061,931.83</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>47,818,531.77</b>	<b>43,061,931.83</b>

## 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,450,462,171.16	759,175,381.32	-753,428,160.37	1,456,209,392.11
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	-0.01	-0.01
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,450,462,171.16	759,175,381.32	-753,428,160.38	1,456,209,392.10
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0	0
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
7	Өмчид гарсан өөрчилөлт	846,417,083.38	0	0	846,417,083.38
8	Зарласан ногдол ашиг	0	0	-17,150,000.00	-17,150,000.00
9	Тайлант үеийн үр дүн	0	0	47,818,531.77	47,818,531.77
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,296,879,254.54	759,175,381.32	-722,759,628.61	2,333,295,007.25
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,296,879,254.54	759,175,381.32	-722,759,628.61	2,333,295,007.25
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,296,879,254.54	759,175,381.32	-722,759,628.61	2,333,295,007.25
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0	0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
17	Өмчид гарсан өөрчилөлт	287,744,955.73	0	0	287,744,955.73
18	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
19	Тайлант үеийн үр дүн	0	0	43,061,931.83	43,061,931.83
20	2023 оны 12-р сарын 30-наарх үлдэгдэл	2,584,624,210.27	759,175,381.32	-679,697,696.78	2,664,101,894.81

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ төгрөгөөр /			
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>3,821,525,468.60</b>	<b>4,887,633,434.38</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>3,821,525,468.60</b>	<b>4,887,633,434.38</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>3,821,525,468.60</b>	<b>4,887,633,434.38</b>
120009	Бусад орлого	115,166,611.60	164,585,364.58
120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/	3,706,358,857.00	4,723,048,069.80
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>3,561,945,546.06</b>	<b>4,610,521,660.44</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,561,945,546.06</b>	<b>4,610,521,660.44</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>3,561,945,546.06</b>	<b>4,610,521,660.44</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>571,834,304.10</b>	<b>653,510,483.49</b>
210106	Ажилагчдад төлсөн /ТӨҮГ/	571,834,304.10	653,510,483.49
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>192,481,612.37</b>	<b>185,176,689.17</b>
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	192,481,612.37	185,176,689.17
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>74,879,480.12</b>	<b>39,377,398.55</b>
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	74,879,480.12	39,377,398.55
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>2,204,116,412.15</b>	<b>3,052,102,397.11</b>
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө /ТӨҮГ/	713,706,911.97	1,042,739,156.70
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	1,490,409,500.18	2,009,363,240.41
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>518,633,737.32</b>	<b>680,354,692.12</b>
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	270,812,260.32	208,691,295.29
210817	Даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	3,982,578.00	3,424,312.00
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	243,838,899.00	468,239,084.83
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>259,579,922.54</b>	<b>277,111,773.94</b>
<b>IV</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)</b>	<b>0</b>	<b>1,600,000.00</b>
140001	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	0	1,600,000.00
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>116,782,400.00</b>	<b>47,000,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>116,782,400.00</b>	<b>47,000,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>116,782,400.00</b>	<b>47,000,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	107,774,909.10	0
225101	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/	9,007,490.90	47,000,000.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-116,782,400.00</b>	<b>-45,400,000.00</b>
<b>VII</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b>	<b>-17,150,000.00</b>	<b>0</b>
<b>25</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ</b>	<b>17,150,000.00</b>	<b>0</b>
250005	Төлсөн ногдол ашиг	17,150,000.00	0
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>125,647,522.54</b>	<b>231,711,773.94</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	28,032,365.18	153,679,887.72
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	153,679,887.72	385,391,661.66

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр/

д/д	Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	Х/н	2022 оны гүйцэтгэл	2023 оны		Харьцуулалт	
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	<b>Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт</b>	<b>м.төг</b>	<b>3,337,362.81</b>	<b>3,020,248.14</b>	<b>4,302,045.12</b>	<b>(1,281,796.98)</b>	<b>142.44</b>
	Улсын чанартай ЗЗА ажил	м.төг	2,570,289.45	2,436,202.88	1,880,954.63	555,248.25	77.21
	Орон нутгийн чанартай ЗЗА ажил	м.төг	767,073.36	584,045.26	2,421,090.49	(1,837,045.23)	414.54
2	<b>Нийт орлого</b>	<b>м.төг</b>	<b>3,361,962.81</b>	<b>3,044,848.14</b>	<b>4,322,545.12</b>	<b>(1,277,696.98)</b>	<b>141.96</b>
	Түрээсийн орлого	м.төг	24,600.00	24,600.00	20,500.00	4,100.00	83.33
3	<b>Нийт зардал</b>	<b>м.төг</b>	<b>3,308,831.11</b>	<b>2,996,173.73</b>	<b>4,274,698.53</b>	<b>(1,278,524.80)</b>	<b>142.67</b>
	Үүнээс: Удирдлагын зардал	м.төг	204,881.54	375,032.95	318,887.27	56,145.68	85.03
4	<b>Татварын өмнөх ашиг /алдагдал/</b>	<b>м.төг</b>	<b>53,131.70</b>	<b>48,674.41</b>	<b>47,846.59</b>	<b>827.82</b>	<b>98.30</b>
5	Цэвэр ашиг /алдагдал/	м.төг	47,818.53	43,806.97	43,061.93	745.04	98.30
6	<b>Төсвийн төлбөрт нийт дүн</b>	<b>м.төг</b>	<b>466,078.28</b>	<b>533,648.43</b>	<b>394,708.83</b>	<b>138,939.60</b>	<b>73.96</b>
	Орлогын татвар	м.төг	8,061.27	4,867.00	1,981.08	2,885.92	40.70
	НӨАТ	м.төг	190,822.31	276,804.38	135,657.49	141,146.89	49.01
	Газрын төлбөр	м.төг	2,041.84	2,300.00	2,500.55	(200.55)	108.72
	Хувь хүний орлогын албан татвар	м.төг	68,745.20	89,745.20	63,124.69	26,620.51	70.34
	Үл хөдлөх хөрөнгийн татвар	м.төг	2,288.08	5,751.25	3,919.35	1,831.90	68.15
	НДШ	м.төг	191,768.88	151,613.15	185,709.99	(34,096.84)	122.49
	Тээврийн хэрэгслийн татвар, бусад татвар	м.төг	2,350.70	2,567.45	1,815.68	751.77	70.72
7	<b>Төрийн өмчийн ноогдол ашиг</b>	<b>м.төг</b>	<b>17,150.00</b>	<b>20,583.36</b>	<b>-</b>	<b>20,583.36</b>	<b>-</b>
8	<b>Нийт ажиллагсдын тоо</b>	<b>Хүн</b>	<b>34.00</b>	<b>61.00</b>	<b>49.00</b>	<b>12.00</b>	<b>80.33</b>
9	Нийт цалингийн сан	м.төг	695,512.86	1,049,607.95	712,944.55	336,663.40	67.92
10	Нэг ажиллагчийн дундаж цалин	м.төг	1,704.69	1,410.76	1,984.96	(574.20)	140.70
11	Борлуулалтын нэг төгрөгт ногдох зардал	төг	1.0	1.0	0.989	(0.00)	100
12	Хөрөнгө оруулалт	м.төг	107,774.91	90,000.00	42,727.27	47,272.73	47.47
13	<b>Нийт авлага</b>	<b>м.төг</b>	<b>135,792.7</b>	<b>110,325.59</b>	<b>8,776.15</b>	<b>101,549.44</b>	<b>7.95</b>
	Үүнээс: найдваргүй	м.төг	-	-	-	-	-
14	<b>Нийт өглөг</b>	<b>м.төг</b>	<b>2,522.00</b>	<b>185,414.34</b>	<b>36,488.21</b>	<b>148,926.13</b>	<b>19.68</b>
	Үүнээс: Богино хугацаат өр төлбөр	м.төг	-	185,414.34	36,488.21	148,926.13	19.68
	Урт хугацаат өр төлбөр	м.төг	-	-	-	-	-

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

---

#### **3.1 Компани/ТӨҮГ, түүний үйл ажиллагаа**

Төв АЗЗА ТӨХК-ын зорилго нь “Улсын чанартай авто замын засвар арчлалт, шугамуудын хэсгүүдийг шуурхай удирдлагаар хангаж, хариуцсан авто зам, замын байгууламжийн бүрэн бүтэн байдалд хяналт тавьж, гарсан эвдрэл гэмтлийг арилгах ажлыг зохион байгуулж, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг саадгүй нэвтрүүлэх, нөхцөлийг бүрдүүлэх”-д оршино.

Төв АЗЗА ТӨХК-ийн дүрэм, 2021/02/007 тоот тусгай зөвшөөрөлд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Таван км хүртэл хатуу хучилттай зам барих;
- Хайрган хучилттай зам барих;
- Зам барилга, засварын материал, хийцийн үйлдвэрлэл;
- Бүх төрлийн зам гүүр, тунель, газар доогуур нүхэн гарам засварлах, замын байгууламжийн арчлалтын ажил;
- Зам, талбайн тохижилтын ажил хийх, засварлах;
- Замын тоноглол, тэмдэг, тэмдэглэгээний ажил, үйлчилгээ эрхлэх;

Монгол Улсын Их Хурлын 2002 оны 16 тогтоолоор баталсан Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэлийн 4 дүгээр зүйлийн 4.1-т “Доор дурдсан төрийн өмчит хуулийн этгээдийн 34 хүртэлх хувийн энгийн хувьцааг нэмж гарган Монголын хөрөнгийн биржээр олон нийтэд нээлттэй худалдан нээлттэй хувьцаат компани болгоно”, 4.1.19-д “Төв АЗЗА ТӨХК” гэж заасан байна.

#### **3.2 Компани/ТӨҮГ-ын гадаад, дотоод орчин**

Авто замын тухай хуулийн 23 дуугаар зүйлийн 23.1-д “Авто замын ашиглалт, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж, арчлалт, урсгал засварын ажлыг тогтмол гүйцэтгэх чиг үүрэг бүхий зам хариуцагч байгууллага байна. Зам хариуцагч байгууллага нь замын арчлалт, засварын ажлыг гүйцэтгэх тусгай зөвшөөрөл бүхий төрийн болон хувийн өмчит хуулийн этгээд байна” гэж заасны дагуу үйл ажиллагаа явуулдаг ЗТХЯ-ны харьяа байгууллага юм.

Компани 100 хувь төрийн өмчит хувьцаат компани бөгөөд хувьцаа эзэмшигчийн бүрэн эрхийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар хэрэгжүүлдэг. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 390 дүгээр тогтоолоор ТУЗ-ийн төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх гишүүнээр томилсон байна.

Төв АЗЗА ТӨХК-ийн төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн тухай хууль, компанийн дүрэмд заасны дагуу төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг 5 удаа зохион байгуулж, 20 асуудал хэлэлцэн 10 тогтоол баталж, хэрэгжилтийг тооцсон байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга, төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хороо, нэр дэвшүүлэх хороо, цалин урамшууллын хороог шинэчлэн томилсон байна. Төлөөлөн удирдах зөвлөл нь ТУЗ-ийн дарга 1, нарийн бичгийн дарга 1, аудитын хороо 3, нэр дэвшүүлэх хороо 3, цалин урамшууллын хороо 3 нийт 10 хүний бүрэлдэхүүнтэй ажиллахаас 9 хүн ажилласан байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн зардалд 35,483.1 мянган төгрөгийг баталснаас 30,772.7 мянган төгрөгөөр гишүүдийн цалингийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Төв АЗЗА ТӨХК төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн үндсэн гэрээг 2020 оны 01 дүгээр сард 15 иргэнтэй гурвалсан гэрээ байгуулан, гэрээний 1.5-д Түрээсийн гэрээг нэг хүртэл жилээр 2 удаа сунгаж болно гэж заасны дагуу 2 удаа сунгаж 2023 оны 01 дүгээр сард дууссан байна.

Төв АЗЗА ТӨХК-аас түрээсийн журмын дагуу сонгон шалгаруулалт явуулах эрх авахаар 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 21 тоот албан бичгийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлж, 2023 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн А-1/290 тоот албан бичгээр зөвшөөрлийг олгосон ч сонгон шалгаруулалт явагдаагүй байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Монгол Улсын Их Хурлын Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл батлах тухай 2022 оны 16 дугаар тогтоол
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 5, 21 дүгээр зүйл
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 203 дугаар тогтоол;

Төв АЗЗА ТӨХК-ийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Компанийн гүйцэтгэх захирлын 2021 оны А/17 дугаар тушаалаар “Дотоод хяналт шалгалтын ажиллах журам”-ыг баталж, дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах үүрэг бүхий нэгжийг 4 ажилтны бүрэлдэхүүнтэйгээр томилсон байна. Дотоод хяналт шалгалтын нэгж нь 2023 оны батлагдсан төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтыг зохион байгуулж ажилласан байна.

Төв аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас хяналт шалгалт хийгээгүй байна.

Дотоод аудит, аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв АЗЗА ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төв АЗЗА ТӨХК-ийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Төв АЗЗА ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 364,773.1 мянган төгрөгөөр буюу 15,6 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
<b>Б</b>	<b>1</b>	<b>2</b>	<b>3=2-1</b>
Мөнгөн хөрөнгө	153,679.9	385,391.7	231,711.8
Авлага	135,792.7	8,776.2	-127,016.5
Бараа материал	135,053.6	135,133.9	80.3
Урьдчилж төлсөн зардал	7,757.9		-7,757.9
Дуусаагүй үйлдвэрлэл		180,531.0	180,531.0
Үндсэн хөрөнгө	1,903,532.9	1,990,757.3	87,224.4
<b>Нийт хөрөнгө</b>	<b>2,335,817.0</b>	<b>2,700,590.1</b>	<b>364,773.1</b>
Өр төлбөр	2,522.0	36,488.2	33,966.2
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,333,295.0	2,664,101.9	330,806.9
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>2,335,817.0</b>	<b>2,700,590.1</b>	<b>364,773.1</b>

Дээрх хүснэгтээс харахад, мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, эздийн өмчийн дансны үлдэгдэл өмнөх оноос өсөж, авлага, дуусаагүй үйлдвэрлэл, өр төлбөрийн дансны үлдэгдэл өмнөх оны үзүүлэлтээс буурсан үзүүлэлттэй байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 231,711.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны эцэст өвлийн зам засвар арчлалтын санхүүжилт шилжүүлж, зарцуулагдаагүй үлдсэн нь нөлөөлсөн байна.
- Бараа материалын дансны үлдэгдэл 80.3 мянган төгрөгөөр өссөн нь 2,056,303.9 мянган төгрөгийн хангамжийн материал бэлтгэн, 2,056,223.6 мянган төгрөгийн материалыг зарцуулсан нь нөлөөлсөн байна.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 87,224.4 мянган төгрөгөөр өссөн нь өөрийн

хөрөнгөөр 42,727.3 мянган төгрөг, үнэ төлбөргүй 245,017.7 мянган төгрөгийн хөрөнгийг хүлээн авч, дуудлага худалдаагаар 1,606.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдсанаас шалтгаалжээ.

- Авлагын дансны үлдэгдэл 127,016.5 мянган төгрөгөөр буурсан нь Төв аймгийн Зуунмод сумын 4 замын уулзварын ажилд “Ялгуусан” ХХК-д туслан гүйцэтгэгчээр ажилласан ажлын хөлсний авлагын үлдэгдлээс 110,325.6 мянган төгрөг, Налайх АЗЗА ТӨХК-аас 2,056.9 мянган төгрөгийн авлагыг тус тус барагдуулсан байна. Төв аймгийн Татварын хэлтсээс 7,660.3 мянган төгрөгийн хүн амын орлогын албан татварын авлагатай гарсан байна.
- Дуусаагүй үйлдвэрлэл дансны үлдэгдэл 180,531.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь Төв аймгийн 100 жилийн ажлын чанарын баталгааны 5%-ийг орон нутгийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулснаас шалтгаалжээ.
- Өр төлбөрийн үлдэгдэл 33,996.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь Ялгуулсан ХХК-д төлөх техникийн түрээс, Тэнгэр уул трейд ХХК-д явган замын хавтангийн үнэ, Татварын хэлтэст төлөх ААНБ-ын орлогын албан татвар төлөөгүйгээс шалтгаалжээ.
- Эздийн өмчийн дансны үлдэгдэл 330,806.9 мянган төгрөгөөр өссөн нь Хурдны замын засвар арчлалттай холбоотойгоор ТӨБЗГ-ын 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн А-1/2128 дугаар тогтоолоор 1 нэр төрлийн 245,017.6 мянган төгрөгийн хөрөнгийг Налайх АЗЗА ТӨХК-аас шилжүүлэн авсан, өөрийн хөрөнгөөр 42,727.3 мянган төгрөгийн хөрөнгө, 43,061.9 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажилласан нь нөлөөлсөн байна.

### **3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Төв АЗЗА ТӨХК нь үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө, техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 581 дүгээр тогтоолоор 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна.

Тайлант оны нийт орлогыг 3,044,848.1 мянган төгрөгөөр, нийт зардлыг 2,996,173.7 мянган төгрөгөөр, 48,674.4 мянган төгрөгийн ашигтай ажиллахаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 90,000.0 мянган төгрөгийг төлөвлөсөн байна.

Төв АЗЗА ТӨХК нь гүйцэтгэлээр 4,322,545.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 4,274,698.5 мянган төгрөгийн зардал гарган, 47,846.6 мянган төгрөгийн татварын өмнөх ашиг, 43,061.9 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

Төв АЗЗА ТӨХК-ийн нийт орлогын гүйцэтгэл 4,322,545.1 мянган төгрөг болж төлөвлөснөөс 1,277,696.9 мянган төгрөг буюу 142,0 хувиар давж биелүүлсэн нь Төв аймгийн 100 жилийн ойтой холбоотой ажил гүйцэтгэснээс шалтгаалсан байна.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 581 дүгээр тогтоолоор түрээсийн орлогыг 24,600.0 мянган төгрөгөөр

баталснаас 20,500.0 мянган төгрөгийг төвлөрүүлж, гүйцэтгэл 4,100.0 мянган төгрөгөөр буюу 17%-иар тасарсан нь Говьсүмбэр аймгийн Орон нутгийн өмчийн газарт шилжүүлснээс шалтгаалсан байна.

Нийт зардлын гүйцэтгэл 4,274,698.5 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 1,278,524.8 мянган төгрөг буюу 142,7 хувиар илүү гүйцэтгэлтэй байна. Энэ нь гүйцэтгэсэн ажлын хэмжээ нэмэгдэж, орлогын төлөвлөгөө 1,277,696.9 мянган төгрөгөөр давж биелүүлсэн нь гол нөлөө үзүүлсэн байна.

Төв АЗЗА ТӨХК-ийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд 90,000.0 мянган төгрөг төлөвсөнөөс өөрийн эх үүсвэрээр 42,727.3 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтын зардлыг санхүүжүүлсэн байна. Тайлант онд цэвэр ашиг 43,061.9 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 745.0 мянган төгрөгөөр буюу 1,7 хувиар буурсан нь үндсэн материалын үнийн өсөлт нөлөөлсөн байна.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Төв АЗЗА ТӨХК төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн үндсэн гэрээг 15 иргэнтэй гурвалсан гэрээ байгуулан түрээсийн орлогоос 22,550.0 мянган төгрөгийг тайлант онд бүрдүүлж, түрээсийн орлогын 40% буюу 9,020.0 мянган төгрөгийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын төрийн сан дахь Төрийн өмчийн түрээсийн 100900000703 тоот дансанд төвлөрүүлсэн байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв АЗЗА ТӨХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх Төв АЗЗА ТӨХК түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах зорилготой холбоотой хөрөнгө данс бүртгэлд тусгах асуудлыг холбогдох газраар шийдүүлэх, түрээсийн орлого, авлага, өр төлбөрийг барагдуулахтай холбоотой зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Бямбасүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв АЗЗА ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн тайланг Төв аймаг дахь Төрийн аудитын газар-т 2024 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 27 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны 3 дугаар улирлын орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогын 3,417,825.6 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 34,178.2 мянган төгрөгөөр тогтоосны 70 хувиар гүйцэтгэлийн материаллаг байдлыг 23,924.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төв АЗЗА ТӨХК тайлант онд 61 орон тоотой ажиллахаас 49 орон тоогоор ажиллаж цалин, НДШ-ийн зардлыг 408,353.2 мянган төгрөгөөр, дулааны төлбөрийг 1,571.9 мянган төгрөгөөр, цэвэр бохир усны зардлыг 370.1 мянган төгрөгөөр, шуудан холбоо, интернэтийн зардлыг 2,475.2 мянган төгрөгөөр, конторын урсгал засварыг 3,706.6 мянган төгрөгөөр, хээр ажиллагсдын томилолтын зардлыг 3,303.7 мянган төгрөгөөр, харуул хамгаалалт, хөдөлмөрийн аюулгүй байдлын зардлыг 13,211.6 мянган төгрөгөөр, ТУЗ-ын зардлыг 4,710.4 мянган төгрөгөөр, бусад зардлыг 837.0 мянган төгрөгөөр, үндсэн үйл ажиллагааны бус зардлыг 56,549.2 мянган төгрөгөөр хэмнэн, дотоод албан томилолт, гар утасны ярианы төлбөрт зардал гаргаагүй ажилласан байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсыг шалгахад 182 мэдээлэл байршуулахаас 173 мэдээлэл хугацаанд нь байршуулж, 9 мэдээлэл хугацаа хоцроож, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 3,593,533.3 мянган төгрөгийн 158 мэдээлэл, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 4,777,529.1 мянган төгрөгийн 52 мэдээлэл, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэлтэй холбоотой 1,141,304.0 мянган төгрөгийн 7 мэдээлэл, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэлтэй холбоотой 33,761.2 мянган төгрөгийн 12 мэдээлэл хугацаанд нь байршуулсан байна.

##### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2023 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 28 дугаар хуралдааны “Төв авто замын арчлалт” төрийн өмчийн хувьцаат компанийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй хөрөнгийг орон нутгийн өмчид шилжүүлэх тухай асуудлыг хэлэлцээд 32 тоот тэмдэглэлээр шийдвэрлэсэн байна.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2023 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн хуралдааны тэмдэглэлээс гэсэн 32 тоот шийдвэрт Төв АЗЗА ТӨХК-ийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 66,004.2 мянган төгрөгийн балансын үнэ, 8,324.8 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй, 57,679.4 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй Говьсүмбэр аймагт байрлах 5 давхар 15 айлын орон сууцыг УИХ, ЗГ-т хүргүүлж төрийн өмчөөс Говьсүмбэр аймгийн орон нутгийн өмчид шилжүүлэх шийдвэр гарах хүртэл 2023 оны 11 дүгээр сарын 01-нээс хөрөнгийн ашиглалт, хамгаалалт, хадгалалт, бүрэн бүтэн байдлыг Говьсүмбэр аймгийн Засаг даргад хариуцуулж шилжүүлэхдээ Төлөөлөн удирдах зөвлөлөөс өмч шилжүүлэх зөвшөөрөлгүй, өмч хамгаалах байнгын комиссын хурлын протокол, дүгнэлтгүй, өмч эзэмшигч байгууллагын зөвшөөрлийг авсан албан бичиг тоот байхгүй, хөрөнгийг хүлээлцсэн акт үйлдээгүй байна.

Төв АЗЗА ТӨХК-иас төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө болох Говьсүмбэр аймагт байгаа 5 давхар 15 айлын орон сууцын ашиглалт, хадгалалт, хамгаалалт,

бүрэн бүтэн байдлыг Говьсүмбэр аймгийн Орон нутгийн өмчийн газарт хүлээлгэн өгсөн акт, баримт бичиг байхгүй байхад иргэдэд түрээслэн, түрээсийн төлбөрийг Гс.түрээсийн орлого 100220000953 тоот дансанд төвлөрүүлэхээр гэрээг хийсэн, иргэдтэй гэрээ хийхдээ Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны “Төрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 02 дугаар сарын 18-ны 50 дугаар тогтоолоор баталсан түрээсийн гэрээний үлгэрчилсэн загварыг мөрдөөгүй байна.

Төв АЗЗА ТӨХК-д ЗТХЯ-аас 2021 онд 67-21ТӨҮ улсын дугаартай МАЗ БИС-310М-01 маркийн тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл, 67-41ТӨҮ улсын дугаартай МАЗ 5905А2-390 маркийн хосолсон ажиллагаатай цэвэрлэгээний машин, Зам Тээврийн Хөгжлийн Төвөөс 2022 онд А-40 Хөшигийн хөндий-Улаанбаатар хурдны замтай холбогдуулан 76-31 УАК улсын дугаартай МАЗ БИС-310М-01 маркийн тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл, 91-46УАВ улсын дугаартай МАЗ 5905А2-390 маркийн хосолсон ажиллагаатай цэвэрлэгээний машин тус тус өгсөн байна.

Төв АЗЗА ТӨХК-д ирүүлсэн дээрхи тусгай зориулалтын болон тээврийн хэрэгсэлүүдийг хатуу хучилттай авто замд нөхөөс хийх, хосолсон ажиллагаатай цэвэрлэгээний машин цас түрэх, шүүрдэх, бодис цацах, замын усалгаа хийх ажлуудад ашиглаж, ашиглалт нь хэвийн, ЗТХЯ, ТӨБЗГ-аас данс бүртгэлд тусгах шийдвэр гараагүй, ямар эх үүсвэрээр ирсэн, бүртгэлд тусгах үнийн дүн тодорхойгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Төв АЗЗА ТӨХК-ийн 2023 оны эхний хагас жилийн баримтад завсрын аудит хийж, аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Төв АЗЗА ТӨХК 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 төлбөрийн акт, цахим баримттай холбоотой 1 зөвлөмжийг 100% хэрэгжүүлэн Төв АЗЗА ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын 2023 оны 6 дугаар сарын 9-ны өдрийн 116 тоот албан бичгээр гарган ирүүлсэн байна.

## Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		/мянган төгрөгөөр/ Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	400.9	2	400.9	100
Албан шаардлага					
Зөвлөмж	1	6,530.4	1	6,530.4	100
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>6,931.3</b>	<b>3</b>	<b>6,931.3</b>	<b>100</b>

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарах асуудал байхгүй байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 102,492.3 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс, 66,004.1 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, 36,488.2 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

### 5.2 Албан шаардлага

1.Төв АЗЗА ТӨХК-ийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 66,004.1 мянган төгрөгийн балансын үнэтэй Говьсүмбэр аймагт байрлах 5 давхар 15 айлын орон сууцыг Говьсүмбэр аймгийн ОНӨГ-т шилжүүлхэд УИХ-ийн шийдвэр гараагүй, өмч эзэмшигч байгууллагын Төлөөлөн удирдах зөвлөлөөс өмч шилжүүлэх зөвшөөрөлгүй, өмч хамгаалах байнгын комиссын хурлын протокол, дүгнэлтгүй, эзэмшигч байгууллагын өмч шилжүүлэх зөвшөөрөл олгосон албан бичиг байхгүй, мөн хөрөнгө хүлээлцсэн акт үйлдээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1-т “Төрийн өмчийн эд хөрөнгийг орон нутгийн өмч бүрдүүлэх зорилгоор үнэ төлбөргүй шилжүүлэх асуудлыг гагцхүү Улсын Их Хурал шийдвэрлэнэ”, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 271 дүгээр тогтоолын 2 дугаар зүйлийн 2.1.1-т “Компанийн хувьд Төлөөлөн удирдах зөвлөлийн, шаардлагатай бол Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр, бусад төрийн өмчит хуулийн этгээдийн хувьд харьяа Төсвийн ерөнхийлөн захирагчийн зөвшөөрөл”; 2.1.3-т “хуулийн этгээдийн өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хурлын тэмдэглэл, дүгнэлт”, мөн тогтоолын 5 дугаар зүйлийн 5.1-д “Эрх бүхий байгууллагын шийдвэрээр болон бусад шаардлагаар төрийн өмчит хуулийн этгээд илүүдэлтэй буюу ашигладаггүй эд хөрөнгийг шилжүүлэх, бусад байгууллагын өмчлөлд байгаа эд хөрөнгийг балансаас балансад шилжүүлэн авахдаа өмч эзэмшигч байгууллагын зөвшөөрлийг авч, холбогдох баримт материалыг энэхүү журамд заасны дагуу бүрдүүлэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” заасныг болон Санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл, зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

### **5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Авлага, өр төлбөртэй холбоотой асуудал.**

##### Илрүүлэлт:

ТӨБЗГ-ын 2022 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 581 дүгээр тогтоолын 3-р дугаар заалтад өр, авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллахыг үүрэг болгосон ч тайлант онд хүн амын орлогын албан татварын авлага 7,660.3 мянган төгрөг, харилцагч 3 байгууллагад 36,488.2 мянган төгрөгийн өглөгтэй гарсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

##### Өгсөн зөвлөмж:

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 12 дугаар сарын 19-ны 581 дүгээр тогтоолын 3-р дугаар заалтыг хэрэгжүүлж, цаашид авлага, өр төлбөр үүсгэхгүй ажиллах.

#### **2. Үндсэн хөрөнгө бүртгэхтэй холбоотой асуудал**

##### Илрүүлэлт:

Төв АЗЗА ТӨХК-д ЗТХЯ-аас 2021 онд 67-21ТӨҮ улсын дугаартай МАЗ БИС-310М-01 маркийн тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл, 67-41ТӨҮ улсын дугаартай МАЗ 5905А2-390 маркийн хосолсон ажиллагаатай цэвэрлэгээний машин, Зам Тээврийн Хөгжлийн Төвөөс 2022 онд А-40 Хөшгийн хөндий-Улаанбаатар хурдны замтай холбогдуулан 76-31 УАК улсын дугаартай МАЗ БИС-310М-01 маркийн тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл, 91-46УАВ улсын дугаартай МАЗ 5905А2-390 маркийн хосолсон ажиллагаатай цэвэрлэгээний машин тус тус данс бүртгэлд тусгагдаагүй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 4 дүгээр зүйлийн 4.1.4-т “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд улсын төсвийн хөрөнгө оруулалт, зээл, тусламж, хандиваар бий болсон хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэхэд үнэ өртөг, эзэмших хуулийн этгээд нь тодорхойгүй болон маргаантай тохиолдолд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт асуудлаа тавьж шийдвэрлүүлнэ”, Нягтлан бодох бүртгэлийн

тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” заасныг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Хөрөнгө данс бүртгэлд тусгах асуудлыг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх.

**3. Түрээсийн орлоготой холбоотой асуудал**

Илрүүлэлт:

Төв АЗЗА ТӨХК-ийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө болох Говьсүмбэр аймагт байгаа 5 давхар 15 айлын орон сууцын ашиглалт, хадгалалт, хамгаалалт, бүрэн бүтэн байдлыг Говьсүмбэр аймгийн Орон нутгийн өмчийн газарт хүлээлгэн өгсөн акт байхгүй байхад иргэдэд түрээслэн, түрээсийн төлбөрийг Гс.түрээсийн орлого 100220000953 тоот дансанд төвлөрүүлэхээр гэрээг хийсэн, мөн төрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээний үлгэрчилсэн загварыг мөрдөөгүй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны “Төрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 50 дугаар тогтоолын 2.3-д “Түрээслэгч-түрээслүүлэгчийн хооронд байгуулсан төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээг батлагдсан загварын дагуу баталгаажуулах, гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавьж ажиллах”, 2.5-д “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээг санхүүгийн жилээр байгуулж, түрээсийн төлбөрийн тооцоог түрээслүүлэгчтэй хагас жил тутам нийлж баталгаажуулах” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн талаарх асуудлыг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 6 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төв АЗЗА ТӨХК-ийн Говьсүмбэр аймагт байрлах 5 давхар 15 айлын орон сууцыг УИХ-ийн шийдвэр гараагүй, өмч эзэмшигч байгууллагын зөвшөөрөл олгосон албан бичиг байхгүй байхад Говьсүмбэр аймгийн Засаг даргад хариуцуулсан байна.	1	66,004.1			1	66,004.1		
Тайлант онд 7,660.3 мянган төгрөгийн авлага, харилцагч 3 байгууллагад 36,488.2 мянган төгрөгийн өглөгтэй гарсан байна.	1	36,488.2					1	36,488.2
ЗТХЯ-аас 2021 онд 67-21 ТӨҮ, 67-41 ТӨҮ, 76-31 УАК, 91-46 УАВ улсын дугаартай тусгай зориулалтын болон тээврийн хэрэгсэл тус тус данс бүртгэлд тусгагдаагүй байна	1						1	
Төв АЗЗА ТӨХК-ийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө болох Говьсүмбэр аймагт байгаа 5 давхар 15 айлын орон сууцыг иргэдэд түрээслэн, төрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээний үлгэрчилсэн загварыг мөрдөөгүй байна.	1						1	
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>102,492.3</b>			<b>1</b>	<b>66,004.1</b>	<b>3</b>	<b>36,488.2</b>

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум  
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр  
Утас: +976 70272582, +976 70273204  
И –мэйл: [tuv@audit.gov.mn](mailto:tuv@audit.gov.mn), Вебсайт: [www.audit.mn](http://www.audit.mn)